

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**
/2024.12.04/

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг шинэчлэн баталсан. Тус тогтоолоор өгсөн үүргийн дагуу аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/59 дүгээр захирамжаар хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 6 бүлэг, 16 салбар чиглэлийн 154 зорилтын хүрээнд 379 арга хэмжээ төлөвлөн баталж, хэрэгжүүлэн ажиллалаа.

Нийт 154 зорилтыг хэрэгжүүлэхээр 381 арга хэмжээ төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 275 арга хэмжээ 100 хувь, 51 арга хэмжээ 90 хувь, 26 арга хэмжээ 70 хувь, 18 арга хэмжээ 50 хувь, 8 арга хэмжээ 30 хувь, 3 арга хэмжээ 0 хувь буюу дунджаар 92,3 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- (Ковид-19) болон бусад халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого” 91 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Хүний хөгжлийн бодлого” 91,4 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Эдийн засгийн хөгжлийн бодлого” 94,2 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Засаглалын бодлого” 92,8 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Ногоон хөгжлийн бодлого” 94 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Бүс орон нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого” 87,5 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг 2024 оны жилийн эцсийн байдлаар салбар бүрээр нь товч танилцуулбал:

**НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН
ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО**

1.1. Ковид 19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах чиглэлээр:

Ковид 19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах чиглэлээр төлөвлөсөн 5 зорилт 10 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 7 арга хэмжээ 100 хувь, 2 арга хэмжээ 90 хувь, 1 арга хэмжээ 30 хувь буюу дунджаар 91 хувийн гүйцэтгэлтэй байна.

Ковид 19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулахын тулд коронавируст халдвар (ковид 19)-ийн үеийн бэлэн байдалд тоног төхөөрөмж, эм тариа, урвалж оношлуур, хамгаалах хувцас хэрэгсэлд 4.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн ба Коронавируст халдвар (Ковид-19)-ын 18'147 тохиолдлыг илрүүлж эмчилгээнд хамруулсан байна.

Коронавирусын эсрэг вакцинжуулалтад 1 дүгээр тунд нийт хүн амын 86,3 хувь, 2-р тунд 81.7 хувь, 3-р тунд 38.8 хувь, 4-р тунд 3.6% хувийг хамруулжээ.

2023 онд Дэлхийн банкны 162.8 сая төгрөгийн санхүүжилтээр “Коронавирусийн халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл”-ийн хүрээнд 400 ширхэг пульсоксиметр, 20 ширхэг Хүчилтөрөгч өтгөрүүлэгч, 18 ширхэг эмнэлгийн хог хаягдал ариутгах автоклав-г аймгийн эрүүл мэндийн салбарт хүлээлгэн өгсөн, улсын төсвийн 354.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт “Молекул биологийн лаборатори”-г 2021 онд байгуулсан, эрүүл мэндийн яамны 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хүчил төрөгчийн бэсрэг үйлдвэр”-ийг барьж ашиглалтад оруулсан байна.

Коронавируст халдвар (ковид 19)-ийн үед эмнэлгийн тусламж үзүүлэх 1 уушги судлалын эмч, ариутгагч 5, эрчимт эмчилгээний эмч 2, сувилагч 2 нарыг мэргэшүүлэн бэлтгэсэн.

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан тархвар судлалын түргэвчилсэн түргэвчилсэн 5 хоногийн сургалтад 42, ариутгагчийн түргэвчилсэн сургалтад 28, лабораторийн түргэвчилсэн сургалтад 28 эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж тандалт, судалгаа, сорьц цуглуулах, голомтын эцсийн халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд дайчлан ажиллуулсан.

ЭМЯ, ЭМХТ, ЭМГ-аас Коронавируст халдвар (ковид 19)-ийн үед хамгаалах хувцас өмсөх, тайлах, онолын сургалтыг эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг бүрэн хамруулж дадлагажуулсан зэрэг арга хэмжээг шат дараалалтай авч хэрэгжүүлсэний үр дүнд ковид-19 цар тахлын хүнд үеийг амжилттай даван туулсан юм.

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1. Эрүүл мэндийн чиглэлээр:

Эрүүл мэндийн чиглэлээр төлөвлөсөн 10 зорилт 36 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 25 арга хэмжээ 100 хувь, 7 арга хэмжээ 90 хувь, 4 арга хэмжээ 50 хувь, буюу дунджаар 92.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

2020-2024 оны хугацаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн шинэ барилга баригдаж ашиглалтад орсоны зэрэгцээ сумын эрүүл мэндийн төвийн шинэ барилга 1, сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөл 2 баригдаж ашиглалтад ороод байна.

Лавлагаа шатлал буюу нэгдсэн эмнэлгээс үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг E-Health, Анхан шатны буюу сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс үзүүлсэн анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг E-Hospital программд бүртгэж эмчийн үзлэг, өвчтөний түүхийг цахим хэлбэрээр цуглуулж байгаа ба Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр аймгийн Нэгдсэн эмнэлэгт Телемедицин-ийг нэвтрүүлж, E-Mongolia флатформаар Эрүүл мэндийн чиглэлийн 12 үйлчилгээг цахимаар үзүүлдэг боллоо.

2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр “Архангай-100 Эрүүл мэндийн хөгжил форум”-аас гарсан орон нутагт сувилагч, тусгай мэргэжилтэн бэлтгэх салбар сургууль байгуулах санаачилгын дагуу нэгдсэн эмнэлийн хуучин барилга,

байгууламжид тулгуурлан АШУҮИС-ийн харьяа “Сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогцолбор” байгуулах санал дэмжигдэж Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15 ны өдрийн 207 дугаар тогтоолын дагуу аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 12 ны өдрийн 13 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 10 дугаар 16-ны өдрийн 462 дугаар тогтоол дагуу нэгдсэн эмнэлгийн барилга, нийтийн эзэмшлийн байгууламжийг АШУҮИС-д шилжүүлсэн.

АШУҮИС-ийн харьяа “Сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цогцолборт 2025 онд дэд бакалаврын 7 сургалтын хөтөлбөр хэрэгжинэ. Уламжлалт, анагаах ухаан, нүүр амны тусламж үйлчилгээг үзүүлж эхэлнэ.

Аймгийн нэгдсэн эмнэлэг 2021 онд Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 2022 онд гүйцэтгэлд суурилсан санхүүжилт бүрэн нэвтэрсэн. Эрүүл мэндийн мэндийн даатгалын ерөнхий газраас 2023 онд Нэгдсэн эмнэлэг, хувийн эмнэлэг 5, сувилал 1, өрхийн эрүүл мэндийн төв 3, сумын эрүүл мэндийн төв 19, эмийн сан 37, нийт 66 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулж 404'281 иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардалд нийт 23.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгоод байна.

Дархлаажуулалтын үндэсний товллын дагуу 0-2 насны хүүхдийн вакцинжуулалтыг 2020 онд 99.0 хувь, 2021 онд 98.1 хувь, 2022 онд 98.0 хувь 2023 онд 97.6 хувь, 2024 оны эхний 10 сарын байдлаар 99.7 хувьтай хамруулаад байна.

Хавдар судлалын үндэсний төвтэй байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд тус төвийн мэс заслын эмч, Нэгдсэн эмнэлгийн мэс заслын эмч нар хамтран 2022 онд элэгний хавдартай 4 өвчтөнд “Элэг тайрах” мэс заслыг хийсэн. Нэгдсэн эмнэлэгт 380.0 сая төгрөгийн өртөг бүхий хавдрын мэс заслын тоног төхөөрөмж нийлүүлэгдэж 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс хавдрын 8 ортой тасгийг шинээр Нэгдсэн эмнэлэгт нээн ажиллуулж эхэлсэн. 2023 онд хөнгөвчлөх эмчилгээ 395, хими эмчилгээ 136, 2024 оны 3 дугаар улирлын байдлаар хими эмчилгээ 111, хөнгөвчлэх эмчилгээ 214 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

“Элэг бүтэн Монгол” арга хэмжээний хүрээнд 2021-2024 оны хугацаанд 17855 хүнд элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээ хийсэн ба элэгний С вирус 509, В вирус 530 тохиолдлыг илрүүлэн хяналтад авсан. Элэгний В,С вирустай илэрсэн иргэдийг вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд хамруулан С вирусийн эмчилгээнд 830 хүн, В вирусийн эмчилгээнд 250 хүнийг хамруулсан. Элэгний В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад 2303 хүнийг хамруулаад байна

Хавдрын аюулгүй Архангай төслийн хүрээнд улсын төсвийн 350.0 сая төгрөгийн санхүүжилтээр иж бүрэн тоноглогдсон машин нийлүүлсэн. Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нараас бүрдсэн хавдрын эрт илрүүлгийн явуулын амбулатори 6 суманд ажиллаж 3'021 хүнийг үзлэгт хамруулж хавдрын шинэ 10 тохиолдлыг илрүүлэн эмнэлгийн хяналтад авсан байна. 2023 онд хавдрын 8 ортой тасгийг шинээр нэгдсэн эмнэлэгт нээн ажиллуулж эхэлсэн ба хавдрын хими,

хөнгөвчлөх эмчилгээ хийгдэж байгаа бөгөөд хавдрын тусламж үйлчилгээний хүртээмжийг орон нутагт нэмэгдүүлэн ажиллаж байна.

Ихтамир, Чулуут, Хайрхан сумдын эрүүл мэндийн төвүүд 2023 онд шүдний кабинет байгуулсан ба шүдний эмчийг үндсэн орон тоогоор авч ажиллуулан хөдөөгийн хүн амд шүдний тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

2020-2023 оны хугацаанд нэгдсэн эмнэлэг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 870 гаруй сая төгрөгөөр нийт 14 автомашин нийлүүлэгдэж түргэн тусламжийн парк шинэчлэл хийгдээд байна. 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сумын эрүүл мэндийн төвд ажиллаж буй 77 багийн бага эмч нарыг (Мотоцикл) унаажуулсан.

Эрүүл мэндийн салбарт эмнэлгийн тоног, төхөөрөмж, эрүүл мэндийн барилга байгууламжид 2020 онд 3.6 тэрбум 2021 онд 11.1 тэрбум, 2022 онд 9.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж эрүүл мэндийн байгууллагуудын хүртээмж чанартай үйлчилгээг үзүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж байна.

2.2. Нийтийн биеийн тамир, спортын чиглэлээр:

Нийтийн биеийн тамир, спортын чиглэлээр төлөвлөсөн 4 зорилт 12 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 8 арга хэмжээ 100 хувь, 2 арга хэмжээ 90 хувь, 2 арга хэмжээ 50 хувь, буюу дунджаар 90 хувийн гүйцэтгэлтэй байна.

“Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжих, биеийн тамир, спортоор хичээллэх ач холбогдлыг ойлгуулах, мэдлэг мэдээлэл олгох, төр, төрийн бус байгууллагын хамтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж буй “Эерэг хандлага-Эрүүл нийгэм” аян, “Цаг гаргая” биеийн тамирын арга хэмжээ, “Олимпын боловсрол ба бие бялдрын хүмүүжил сэдэвт болзолт уралдааныг орон даяар зохион байгууллаа. “Цаг гаргая” биеийн тамирын арга хэмжээний хүрээнд иргэдийг идэвхжүүлэх, хандлагыг өөрчлөх чиглэлээр сорилын аян, иог, гимнастик, дугуй, гийр, шугаман бүжиг, фитнес, алхалт, гүйлтийн арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд дээрх арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 3’860 иргэн хамрагдлаа. ЭМГ, БТСГ-аас хамтран “Энэ жилдээ-Эрүүл жиндээ”, “Эрүүл чийрэг эр хүн” аяныг зохион байгуулж иргэдэд цусны болон сахрын шинжилгээ хийн, биеийн өндөр жин, даралтыг хэмжиж, зөв хооллолт, идэвхтэй дасгал хөдөлгөөн хийхийн ач холбогдлын талаар зөвлөмж мэдээлэл өгсөн бол “Эрчүүдийн өдөрлөг”-ийг Өндөр-Улаан, Хайрхан, Батцэнгэл, Чулуут сумдад зохион байгуулж 600 гаруй эрэгтэйчүүдийг хамруулан эмчийн үзлэг, эрүүл мэндийн мэдлэг олгох сургалт зохион байгуулжээ.

2022, 2023 онд нийтийн биеийн тамир, спортын 106 арга хэмжээнд давхардсан тоогоор 70’845 хүн хамрагдсан нь өмнөх оноос 5 дахин өссөн үзүүлэлт юм.

Үндэсний спортоос мөсний шагай, мөсний сур, шагайн харваа, үндэсний бөх, сурын харваан спорт түлхүү хөгжиж, хичээллэгчдийн тоо өмнөх оноос 13%-аар өссөн байна. 2022, 2023 онуудад “Бөхбилэгт” дэвжээний бөхчүүдийн бэлтгэл сургуулилт, Мөсний шагайн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцогчид,

аймгийн Засаг даргын нэрэмжит үндэсний бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн, “Тайхарын тойром” гар шагайн харвааны үндэсний хэмжээний тэмцээн, Үндэсний спортын YII наадамд оролцогчид, “Монгол брэнд-Морин өртөө” морин спортын улсын уралдаан, мөсний шагайн улсын цол олгох харваан тэмцээн, Архангай аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээний нээлтийн барилдаан, зэрэг арга хэмжээнүүдэд орон нутгийн төсвөөс 73.0 сая төгрөгийг зарцуулан ажиллалаа. Үндэсний спортын VII наадамд Архангай аймгийн баг тамирчид спортын 11 төрөлд 56 тамирчин, багш дасгалжуулагч нийт 78 хүний бүрэлдэхүүнтэйгээр амжилттай оролцож, "Хүрэл медаль, цом"-ын эзэд боллоо.

Цэргийн цол, чимэг олгодог 32 дахь удаагийн "Бүх цэргийн наадам", Граунд гольф, Жүдо бөхийн залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн, Тайхарын тойром гар шагайн үндэсний тэмцээнүүдийг аймагтаа зохион байгуулж, 23,0 сая төгрөгийг зарцуулан, Даамын Азийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон 6 сурагчийг урамшуулах, даам, жюү жицү, чөлөөт бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох 1 багш 8 сурагч, бадминтоны Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох 2 сурагчид нийт 9.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Даамын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн сурагч Б.Эрмүүнзаяа алтан медаль хүртэж дэлхийн аварга болсон бол мөн сургуулийн сурагч Э.Эрхэмбаяр тус тэмцээнээс хүрэл медальт хүртсэн байна.

Хөл бөмбөг, сагс, волейбол зэрэг багийн спортоор хичээллэгчдийн тоо өмнөх оноос 2 дахин өссөн байна. БТСГ-т хичээллэдэг сагс, волейбол, хөл бөмбөгийн секцэд нийт 218 тамирчин хичээллэж байгаа бол эдгээр багийн спортоор тогтмол хичээллэдэг 1'152 тамирчин байна. 2023 онд Сагсан бөмбөгийн охидын баг U17 насны улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож алтан медаль хүртэн улсын аварга болсон бол U-16 насны охидын баг улсын аваргын шагналт 4-р байрт шалгарлаа. Хөл бөмбөгийн охидын баг U-15 насны ангиллын футзалын улсын аварга шалгаруулах тэмцээнээс 2022 онд хүрэл медаль, 2023 онд алтан медаль тус тус хүртсэн байна. Орон нутгийн төсвөөс Сагсан бөмбөгийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцогчдод 1.0 сая, Үндэсний цом хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцогчдод 2.5 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүллээ.

2023 онд аймгийн тамирчид олон улс, тив дэлхийн хэмжээний тэмцээнээс 3 алт, 2 мөнгө, 15 хүрэл нийт 20 медаль, “Хүүхдийн спортын YII наадам”-аас 5 алт, 6 мөнгө, 4 хүрэл нийт 15 медаль, улсын аварга шалгаруулах тэмцээний 19 төрлөөс 31 алт, 39 мөнгө, 44 хүрэл нийт 114 медаль хүртсэн амжилтыг үзүүллээ.

Усан бассейны барилга ашиглалтад орж 10 орон тоотойгоор үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш 11 сарын хугацаанд нийт 790 орчим иргэнд үйлчилсэн байна. Аймгийн Баяр наадмын талбайг орон нутгийн төсвийн 100.0 сая төгрөгийн санхүүжилтээр засварлалаа.

2.3. Өрсөлдөх чадвартай боловсрол:

Өрсөлдөх чадвартай боловсролын чиглэлээр төлөвлөсөн 16 зорилт 54 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 37 арга хэмжээ 100 хувь, 9 арга

хэмжээ 90 хувь, 1 арга хэмжээ 70 хувь, 7 арга хэмжээ 50 хувь, буюу дунджаар 91,3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл зүйн кабинетад сүүлийн 2 жилд улсын төсвийн 698.5 сая төгрөгийн санхүүжилтээр 25 ухаалаг самбар, 810 таблет, 167 зөөврийн компьютер, 20 суурин компьютер, 10 телевиз, 3 принтер, 120 утасгүй сүлжээний төхөөрөмжөөр хангагдлаа. Боловсрол, шинжлэх ухааны газар болон Эрдэнэбулган сумын 1 дүгээр сургуульд БШУЯ-ны санхүүжилтээр мультимедиа студийг нээснээр багш, мэргэжилтнүүдэд цахим контент бэлтгэх нөхцөл бүрдлээ. Сургууль, цэцэрлэгийн багш нар нийтдээ 464 цахим контентыг бэлтгэн сургалтдаа ашиглаж байна. МСҮТ-үүдийн багш нарын цахим хичээлийн арга зүйг сайжруулах “Хамтын хичээл”, “Цахим хичээлийн уралдаан”-ныг зохион байгуулж, 700 гаруй цахим хичээл 210 гарын авлага, 1027 хэвлэмэл материалыг сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна.

2023-2024 оны хичээлийн жилд үндсэн сургалтад 5859 хувилбарт сургалтад 1349 хүүхэд нийтдээ 7208 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 89.7 хувьд хүрлээ. 5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт 100 хувь буюу нийт 1782 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж, сургуульд бэлтгэгдэж байна.

Ерөнхий боловсролын 30 сургуулийн 1 дүгээр ангийн 1932 сурагчдыг холбогдох журмын дагуу сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээнд хамруулж математикийн энгийн төсөөлөл, нийгэмшихүй, хэл яриа, байгаль-нийгмийн орчин, дүрслэх урлаг, хөгжим, хөдөлгөөн эрүүл мэнд гэсэн 7 чиглэлээр үнэллээ. Үнэлгээгээр улсын дунджаас дээгүүр буюу 75.0%-тай үнэлэгдсэн байна.

Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй 199 суралцагч хамрагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулахад туслалцаа үзүүлэх зорилготой “Дэмжлэгийн баг” 15 сургуульд ажиллаж байна.

2021-2024 оны хичээлийн жилүүдэд “Боловсрол нөхөн олгох хөтөлбөр”-ийн сургалтад хамрагдсан 495 суралцагчдаас 240 суралцагч суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, үнэмлэх авч дараагийн шатны сургуульд элсэн суралцах боломжтой боллоо.

БШУ-ны сайдын 2024 оны А/258 дугаар тушаалаар Архангай мэргэжлийн боловсролын сургуулийн ангиллыг ахиулж Политехник коллеж болгосон байна. Архангай, Гурвантамир политехник коллежууд Булган мэргэжлийн боловсролын сургууль нь өөрийн дадлагын 33 байртай бөгөөд тус коллеж, сургуулиуд нь өөрийн дадлагын байранд 471, аж ахуйн нэгжид 482 оюутныг тус тус дадлагад хамруулжээ. Архангай, Гурвантамир политехник коллежууд, Булган мэргэжлийн боловсролын сургууль төгсөгчдаас мэргэжлээрээ ажиллаж буй төгсөгчийн эзлэх хувь 61,6, МУБИС-ийн Архангайн багшийн сургууль төгсөгчид бүгд ажлын байртай болсон байна.

БШУГ-аас бага боловсролын 2875, суурь боловсролын 10387, бүрэн дунд боловсролын 12571 даалгаврын санг судлагдахуун тус бүрээр бүрдүүлэн суралцагчдын сурлагын ахиц дэвшлийн үнэлгээг тогтмол хийн үр дүнг тооцон ажиллаж байна.

Элсэлтийн ерөнхий шалгалтад Архангай аймгийн шалгуулагчид 2021 онд 521.3, 2022 онд 512.7, 2023 онд 507.3 хувийн дундаж үнэлгээтэйгээр шалгагдсан байна.

Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлөөс монгол бичгийг богино хугацаанд шинэлэг хэлбэр, хялбар аргаар сургах цахим контент, цахим хичээл, теле хичээлийн сан үүсгэж баяжууллаа. Багш нар, албан хаагчид, хувь хүмүүст зориулан “Bolorsoft” цахим толь гаргасан "Тунгаамал толь"-ийн холбоосыг монгол бичигтэй холбоотой цахим талбаруудад, монгол бичгийн 25 цахим хичээлийг олон нийтийн сүлжээгээр түгээсэн байна.

БШУЯ-аас төрийн албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлыг хангах, төрийн албан хаагчдаас үндэсний бичгийн сургалтын түвшин тодорхойлох сорилго авч, төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг дээшлүүлэх цахим бичвэр боловсруулах арга зүйд сургах сургалтыг аймгийн нийт төрийн байгууллагын албан хаагчид болон архив бичиг хэргийн эрхлэгч, ажилтнуудад зохион байгуулж 173 хүн оролцлоо. Аймгийн ЗДТГ-ын Архивын тасгаас төрийн байгууллагуудын хэвлэмэл хуудаснуудыг үндэсний бичгээр хэвлүүлснийг хянан баталгаажуулж байна. Аймгийн ЗДТГ 4 дүгээр сараас харилцах албан бичгүүд /А5, А4/-ийг кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэж эхэлсэн.

Багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэх үндэсний тогтолцоо бүрдэж жил бүр үндсэн, үндэсний, бүсийн, орон нутгийн, ажлын байрны сургалтад багш нар бүрэн хамрагдаж мэргэжил боловсрол, хичээл заах арга зүй ур чадвараа дээшлүүлж байна.

“Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд “Шилдэг багш” “Шилдэг байгууллага”-ыг шалгаруулах уралдааныг зохион байгуулж, шалгарсан байгууллага, багш нарыг шагнаж урамшууллаа. Шилдэг багшаар 16 багшийг шалгаруулж 41.0 сая, шилдэг мэргэжлийн хөгжлийн бүлгээр 8 бүлгийг шалгаруулж 40.0 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.

Багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 26.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүллээ.

Энэ хичээлийн жилд боловсролын салбарт зөвлөх багш 12, тэргүүлэх багш 410, заах аргач 604 багш тус тус ажиллаж байна. Ментор багш нарыг үе шаттайгаар бэлтгэн ЕБС, хүүхдийн цэцэрлэгүүдэд ажиллуулж байна. Одоогоор 84 ментор багш ажиллаж байна.

Улсын төрөлжсөн олимпиадын Математик, Түүх, Нийгмийн ухаан, Англи хэлний хичээлийн төрөлд 2-3-р байр эзэлсэн 5 сурагч, тэднийг бэлтгэсэн 5 багш, элсэлтийн ерөнхий шалгалтад 750-с дээш оноо авсан 48 сурагчид, тэднийг бэлтгэсэн 47 багшийг 21.8 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа. Олон улсын оюутны Математикийн олимпиадаас хүрэл медаль, хими, биологийн хичээлээр мөнгө хүрэл хүртсэн ШУТИС-ийн оюутан болон 1-р сургуулийн сурагчийг 5.9 сая төгрөгөөр шагнаж урамшуулан, МУБИС-ийн Архангай дахь багшийн сургуулийн Монгол хэлний багшийн докторантурын сургалтын төлбөрт 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, их дээд сургуульд суралцаж буй бүтэн өнчин 16 оюутанд 18.0 сая төгрөгийн төгрөгийн тэтгэлэг олголоо.

Үдийн хоолны үйлчилгээнд ерөнхий боловсролын 30 сургуулийн 1-5-р ангийн 9783 сурагчид 100% хамрагдаж байна. Сургууль, цэцэрлэгүүд сурагчдад цэвэр ус уух нөхцөл боломжийг бүрдүүлэн 21 сургуульд 133 ширхэг, хүүхдийн 22 цэцэрлэгт 73 ширхэг нийт 226 ширхэг ус цэвэршүүлэх төхөөрөмжийг хичээл сургалтын байранд байршуулсан байна.

2022-2024 онуудад 7 цэцэрлэг, 10 сургууль, 5 дотуур байранд нийт 175.5 сая төгрөгийн гал тогооны техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн байна.

2020-2024 онд “Эрдэнэт” ТӨҮГ-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих төслийн хүрээнд 1, 2, 3, 4-р ээлжид Архангай аймгийн 18 сум, 6 багийн төвийн ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, дотуур байр бүрэн хамрагдсан. Үүнээс 1, 2, 3-р ээлжийн ажлыг 100% гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Дээрх ажил хийгдсэнээр цэцэрлэгийн хүүхдүүд болон сургуулийн сурагчдын ая тухтай орчинд сурч боловсрох таатай орчин нөхцөл бүрдлээ. 4-р ээлжийн ажлын гүйцэтгэл 70 хувьтай хэрэгжиж байна.

Энэ ажлын хүрэнд сургууль цэцэрлэгийн нийт 64 байгууллагын ариун цэврийн байгууламжийг сайжруулах ажил 2021 оноос эхэлсэн бөгөөд 18 байгууллагын АЦБ-ийн ажил бүрэн хийгдэж дууссан, 26 байгууллагын АЦБ-ийг сайжруулах ажил 10-98 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна

Улсын төсвийн 1.977.990.000 /нэг тэрбум есөн зуун далан долоон сая есөн зуун ерэн мянга/ төгрөгний хөрөнгө оруулалтаар баригдсан “Багшийн хөгжил судалгаа, арга зүйн төв”-ийг “Архангай аймгийн Шинжлэх ухаан, инновацийн төв” болгон 2024 оноос Насан туршийн Суралцахуйн Төвд хариуцуулсан. Тус төвийг аймгийн ОНХС-ын 98.829.679 /ерэн найман сая найман зуун хорин есөн мянга зургаан зуун далан есөн/ төгрөгөөр бүрэн тохижуулж, 182.520.000 /зуун наян хоёр сая таван зуун хорин мянган/ төгрөгний тавилга тоног төхөөржөөр хангаж, нээлттэй сургалтын нэгдсэн төв болгосон бөгөөд тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэж байна. Тус төвийн Цахим анги, Студийн анги, Байгалийн ухааны лаборатори анги, Сургалтын том танхим, Монголын оюун ухааны академийн Архангай салбар Эрдэм стейс боловсролын төвийн Архангай салбарт сургууль цэцэрлэгийн хүүхэд багачууд хамрагдан суралцаж, хөгжиж байна.

“Багшийн хөгжил, судалгаа арга зүйн төв”, Чулуут сумын 320 суудалтай хичээлийн байрны өргөтгөл, спорт заал, Хашаат, Өлзийт сумдын сургуулийн өргөтгөл, Батцэнгэл сумын 150 ортой цэцэрлэг, Чулуут сумын сургуулийн өргөтгөл, спорт заалны барилга, Хашаат, Өлзийт, Эрдэнэбулган сумын 4-р сургуулийн өргөтгөлүүд, Цэцэрлэг, Цахир, Ихтамир, Эрдэнэбулган сумын 2-р цэцэрлэгийн өргөтгөлүүд, Төвшрүүлэх, Хотонт, Жаргалант, Эрдэнэбулган сумын 2-р цэцэрлэгүүдийн барилга ашиглалтад орж үйл ажиллагаа эхэлсэн.

2022-2024 онуудад орон нутгийн төсвийн 1,661.9 сая төгрөгийн санхүүжилтээр Эрдэнэбулган сумын Ирээдүй цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор, ерөнхий боловсролын 5-р сургууль, Өлзийт, Өгийнуур, Цэнхэр, Хотонт, Хайрхан, Ихтамир сумдын хичээлийн байр, Төвшрүүлэх сумын сургуулийн дээвэр, Батцэнгэл, Хотонт, Өндөр-Улаан, Өгийнуур сумдын сургуулийн спорт заал, Эрдэнэбулган сумын Хоршоолол багийн сургуулийн спорт заалны халаалтын шугам, 4-р сургууль,

5-р цэцэрлэгийн бохир усны шугам сүлжээ, 9-р цэцэрлэгийн барилгыг тус тус засварлах зэрэг хөрөнгө оруулалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

2.4. Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал:

Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр төлөвлөсөн 14 зорилт 39 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 34 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээ 90 хувь, 3 арга хэмжээ 50 хувь, 1 арга хэмжээ 30 хувь, буюу дунджаар 94,1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тэтгэврийг үе шаттай нэмэгдүүлнэ гэж заасны дагуу нийт 4 удаа шат дараатай нэмэгдүүлсэн бөгөөд хамгийн сүүлд Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 120 дугаар тогтоолоор 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс бүрэн тэтгэврийн доод хэмжээ 650000 мянган төгрөг, хувь тэнцсэн тэтгэврийн доод хэмжээ 540000 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэнээр аймгийн хэмжээнд **16873** тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдсэн байна. Мөн өдрийн Засгийн газрын 238 дугаар тогтоолоор тэтгэвэр бодох итгэлцүүрийг шинэчлэн баталж аймгийн хэмжээнд 4300 гаруй тэтгэвэр авагчийн тэтгэвэр бодитойгоор нэмэгдээд байна. Тэтгэврийг нэмэгдүүлснээр улсын хэмжээнд дундаж тэтгэвэр 795100 төгрөг болж 14.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Сайн дурын даатгалд 2600 малчин шинээр хамрагдаж сайн дурын даатгалд даатгуулсан иргэдийн тоо 6100 гаруй болж өмнөх оны мөн үеэс 268 даатгуулагчаар буюу 21,6 хувиар өссөн байна.

Нийгмийн халамжийн 11 ангиллын 71 төрлийн үйлчилгээ бүрэн цахимжиж, Нийгмийн халамжийн сангаас үйлчилгээ авагч 38'440 иргэн ENALAMJ.MN халамжийн нэгдсэн системд дансаа тохируулснаар, арилжааны банкин дахь өөрийн нэрийн дансаар мөнгөө түргэн шуурхай авч байна.

Насны хишиг тэтгэмжийн үйлчилгээнд 5251 ахмад настныг хамруулж 841.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв”-ийн барилгын ажлын явц 60 хувьтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комисс нь 24 удаа хуралдаж 338 хүүхдийн асуудлыг хэлэлцэж 298 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, 40 хүүхдийн биеийн байдал сайжирсан, насанд хүрсэн шалтгааны улмаас эмчийн хяналтанд буцаасан байна.

Мөн Хүүхэд гэр бүл хөгжил, хамгааллын газраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжил болон эрүүл мэндийг дэмжих зорилгоор Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулдаг 5 төрлийн сургалтын төв, дугуйлан секцэд хөгжлийн бэрхшээлтэй 11 хүүхдийг хамруулж, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 1 хүүхдийг урт хугацаанд нөхөн сэргээх төвд холбон зуучилж, 21 хүүхдийг “Амреда мед” сувилалд хэвтүүлэн эмчлүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрууллаа. Дээрх үйл ажиллагаанд 12.5 сая төгрөг зарцуулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэнд 128.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэн ажлын

байртай болсон. Санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй 49 иргэнийг зээлийн өмнөх сургалтад, дэмжлэгт хамрагдсан 20 иргэнийг зээлийн дараах сургалтад хамруулсан.

Цөөн мал бүхий өрхүүдийг малжуулахад 200 хүртэлх тооны толгой малтай 19 сумын 300 малчин өрхийг сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн сонгон шалгаруулсан. Сонгогдсон 300 малчин өрхөд 2,400,0 сая төгрөгөөр мал худалдан авч өгөн, цөөн малтай малчин өрхийн малын тоо толгойг нэмэгдүүлсэн.

Бичил үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгч 52 иргэнд 450,000,0 мянган төгрөгийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгийг олгон, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлснээр ажлын байрыг нэмэгдүүлсэн.

“Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн дагуу үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 81 иргэний хүсэлтийг хүлээн авч, шаардлага хангасан 49 төсөлд 997000,0 мянган төгрөгийн жижиг зээлийг олгосны үр дүнд нийт 49 ажлын байр хадгалагдан, 21 шинэ ажлын байр бий болсон байна.

Ахмадад санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж хувиараа хөдөлмөр эрхлэгч 48 ахмад настанд нийт 240,0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгож, 40 ахмад настан хувиараа хөдөлмөр эрхлэн, өрхийн орлогоо нэмэгдүүлж байна.

Мод тарих, ногоон ажлын байрыг бий болгох арга хэмжээнд ажил хайгч иргэд болон нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай 78 иргэнийг хамруулан 31,2 сая төгрөгийн цалин хөлс, нийтийн эзэмшлийн өмч хөрөнгө, дэд бүтцийг сайжруулах, орчны хог хаягдал цэвэрлэх, малын сэг зэм устгалын ажилд 928 иргэнийг хамруулан 398.4 сая төгрөгийн цалин хөлсийг тус тус олгож, өрхийн орлогыг нь нэмэгдүүлж түр ажлын байраар хангасан байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний гэрийн асрамж халамжийн үйлчилгээ, сургалт, сэргээн засах, өдрийн үйлчилгээнд 72 иргэнийг хамруулж 9,150,0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн хамт олны бүлэг бүрдүүлж орлогын эх үүсвэртэй болох сүү цагаан идээ боловсруулах, цайны газар, хэрчсэн гурил үйлдвэрлэл, эко хүлэмж, чацарганы мод, төмс, хүнсний ногоо, мужаан, оёдол, монгол гутал хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулах нийт 18 сумын 20 бүлгийн төсөлд 44 иргэнийг хамруулж 34.995 мян. төгрөгийн санхүүжилт олгосон.

Тус үйлчилгээнд 78 ахмад настан, 20 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 15 өрх толгойлсон эх, 1 хүнд нөхцөлд байгаа хүүхэд, 2 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхийн нийт зорилтот бүлгийн 116 иргэнийг хамрууллаа.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх, багаар ажиллаж ирээдүйтэй санааг хөгжүүлэх арга хэмжээнд шалгарсан 3 бүлгийг бэлтгэл хурдасгуур хөтөлбөрт хамруулан бойжуулж шилдэг 2 старт-апп бүлгийг шалгаруулж, 20.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Хүүхэд хөгжлийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 10 төрлийн сургалт нөлөөлийн ажилд 11300 хүүхэд хамрагдаж, 30,781 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан.

Хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагын хүүхдүүдийг хөгжүүлэх чиглэлээр 8 удаагийн сургалт нөлөөллийн үйл ажиллагаа, уралдаан, тэмцээнд 839 хүүхдийг оролцуулан нийт 30.021.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

“Хүүхэд хөгжлийн ордонтой” болох арга хэмжээний хүрээнд Хөгжимт драмын театрын шинэ барилга ашиглалтад орж театрын хуучин барилгыг стандарт шаардлагуудыг хангасны үндсэн дээр Хүүхдийн ордны асуудлыг хуучин театрт нээн ажиллуулахаар төлөвлөсөн зураг төсөв, судалгааны ажил хийгдэж эхэлсэн.

Хүүхдийн “Тамир” зуслангийн их засварын ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 275.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Гурван тамир” ХХК хийж гүйцэтгэн, ашиглалтанд хүлээж авлаа.

Тамир” зусланд 4 ээлжинд 663 хүүхдийг хүлээн авч хүүхэд хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласан. Зуслангийн хөгжлийн хөтөлбөрт тэгш хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хагас бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг оролцуулан Өвөрхангай-200, Архангай-200 нийт 400 хүүхдийг үнэ төлбөргүй амрааж, оролцоог нэмэгдүүлж, хөгжлийг дэмжиж ажилласан байна. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд нийт 70.0 сая төгрөг зарцуулсан байна

Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг 11 байгууллагын 860 оролцогчийн бүрэлдхүүнтэй зохион байгуулсан.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран “Эрсдэлгүй ирээдүйн төлөө-Хамтдаа” хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлж архины хамаарал бүхий гэр бүлтэй ажиллаж буй мэргэжилтнүүд, хөтөлбөрт хамрагдаж буй иргэдэд зориулсан сургалтыг зохион байгуулж, тус хөтөлбөрт 19 хүн хамрагдаж, мөн Үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй “Гэртээ эрт харья” аяны хүрээнд 13 удаагийн сургалт, нөлөөлийн арга хэмжээнд 565 гэр бүл буюу 1130 иргэн хамруулж, 63 байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан байна.

2.5. Үндэсний өв соёл, соёл урлаг:

Үндэсний өв соёл, соёл урлагийн чиглэлээр төлөвлөсөн 10 зорилт 36 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 20 арга хэмжээ 100 хувь, 9 арга хэмжээ 90 хувь, 4 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 50 хувь, 2 арга хэмжээ 30,0 хувь буюу дунджаар 89,0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн хэмжээнд соёл урлагийн нийт 21 байгууллага үйл ажиллагаа явуулж тэдгээрт нийт 225 албан хаагч ажиллаж байна. ХДТ, Номын сан, Музейн нийт албан хаагчдаас мэргэжилтэй уран бүтээлч, албан хаагчид 93-98%-ийг эзэлж байгаа бол 18 соёлын төвийн нийт албан хаагчдын 50% буюу 48.8 нь мэргэжлийн боловсон хүчин байна. Архангай 100-Соёлын хөгжил” форумыг 2023 оны 3 дугаар сард зохион байгуулж УИХ, ЗГ-ын гишүүд, Соёлын яамны холбогдох газар хэлтсийн дарга нар, аймгийн удирдлагууд, сумдын соёлын төвүүд, аймгийн ХДТ, Музей, Номын сан, Гэрэл зурагчдын холбоо, Зураач урчуудын холбоо, соёлын бүтээл үйлдвэрлэгч

иргэд зэрэг 200 гаруй хүн оролцов. Форумд оролцогчид салбарын өмнө тулгамдаж буй асуудлаа хэлэлцэн хэрхэн шийдвэрлэх, хэрэгжүүлэх санал зөвлөмжийг гарган хэрэгжүүлж байна. Соёл урлагийн албан хаагчдын мэргэжил боловсролыг дээшлүүлэх болон соёлын ажилтны өдрийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнүүдэд 2022, 2023 онд орон нутгийн төвөөс 21.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын www.rich.mongoluv.mn цахим программд 321 дурсгалт газрын 4070 гаруй дурсгал, Register цахим программд түүх, соёлын хөдлөх дурсгалын 2193 дэсийн 4639 дурсгал тус тус бүртгэлтэй байна. Эдгээрээс “Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д Архангай аймгийн 10 сумын 22 дурсгал, БСШУС-ын сайдын 2020 оны А/161 дүгээр тушаалаар баталсан “Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д 16 сумын 39 дурсгал тус тус багтсан. Энэхүү 57 дурсгалыг иргэн хуулийн этгээдээр гэрээгээр хариуцуулан хамгаалуулж байна.

Музейгээс 2019-2024 онуудад Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран нийт 12 үзмэрийг сэргээн засварласан.

Орон нутгийн төсвийн 34.7 сая төгрөгийн санхүүжилтээр Музейн Гүдэн сүмийн дээвэр, Баруун сэмчингийн 1 дүгээр давхрын шалыг засварлаж, Музейн хосгүй үнэт үзмэр болох Чонон хөшөөг хамгаалан сүүдрэвч хийг, 12 камерыг суурилууллаа. Виртуал өв соёл төслийн хүрээнд “Архангай аймгийн виртуал музей”-н ажил дуусаж www.vrnomadic.mn сайтад музейн виртуал аяллын линк тавигдсан байна. “Төв Азийн түүх соёлын голомт судалгаа, сурталчилгаа, хамгаалалтын төв”-ийг Өлзийт сумын Бодонтын дөрөлжид байгуулан, Соёлын яамнаас 48.8 сая төгрөгийн санхүүжилтээр тус төвд шаардлагатай тавилга, техник тоног төхөөрөмжөөр хангаж бана.

Архангай аймгийн зохиолчид, зураач урчууд, гэрэл зурагчдын бүтээлээс бүрдсэн “Хантамирын ай” номыг орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгийн санхүүжилтээр бүтээлээ. Мөн “Тулгар төрийн өлгий-АРХАНГАЙ” бүтээлийг аймгийн Засаг даргын тамгын газар, Конрад-Аденауэрийн сантай хамтран бүтээж олны хүртээл болгоод байна. Аймгийн 100 жилийн ойн хүрээнд “Архангай товч түүх-100” ном, “Архангай” фото альбом, Архангай аймгаас төрөн гарсан яруу найрагч, хөгжмийн зохиолчдын бүтээсэн дуунуудаас бүрдсэн “Хангайн дуу” цомгийг хандив тусламж, орон нутгийн төсвөөр эрхлэн гаргаж түгээлээ. Мөн аймгийн зураач урчуудын холбоотой хамтран “Дөрвөн цагийн хангай” уран зургийн үзэсгэлэнг Улаанбаатар хот болон аймагтаа гаргалаа.

Соёлын сайдын багцаас 2022 онд Чулуут, Цэцэрлэг сумын соёлын төвд 83.0 сая төгрөгийн эд хогшил, тайзны хөшиг, хөгжмийн зэмсэг, техник тоног төхөөрөмж нийлүүлж, 168.0 сая төгрөгийг орон нутагт эрх шилжүүлсний дагуу аймгийн түүх, соёлын дурсгалт зүйлсийг сурталчлах түгээн дэлгэрүүлэх контент бүтээх ажлыг “Хангайн даваа” ХХК гүйцэтгэж нийт 50 контентыг хүлээлгэн өгсөн бол 2023 онд Соёлын яамнаас соёл урлагийн 21 байгууллагад 123,5 сая төгрөгийн тавилга, эд хогшил, компьютер, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газартай хамтран “Төрийн тахилгат Суварга хайрхан ууланд холбогдох түүх, шашин, соёлын судалгаа” ЭШХ,

Төгсбаясгалант буяндэлгэрүүлэх хийдтэй хамтран Халхын анхдугаар Зая бандида Лувсанпэрэнлэйн мэлмий гийсний 380, долоодугаар зая бандида Лувсанданзанпүлжинжигмэд гэгээнтний мэндэлсний 50 жилийн ойд зориулсан ЭШБХ, аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд “Эртний төрт улсуудын өлгий нутаг” ЭШХ-ыг тус тус зохион байгуулж орон нутгийн төсвөөс нийт 30,7 сая төгрөгийг зарцуулж, “Эртний төрт улсуудын өлгий” ЭШХ-ын илтгэлүүдийн эмхэтгэлийг хэвлүүлэн нийтийн хүртээл болголоо

Аймгийн Нийтийн номын сангаас “Ээждээ захидал бичээрэй”, “Аавдаа захидал бичээрэй”, “Үлгэрч аав, ээж”, “Би ном унших дуртай”, “Үндэсний бичиг үсгийн баяр”, “Номын баяр”, “Номын баяр-Архангайд”, “Бидний урлан”, “Угийн бичгээ хөтөлцгөөе” арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж байна. МҮОНРТ, МЗЭ, Архангай аймгийн ЗДТГ хамтран “Утгын чимэг” богино өгүүллэгийн наадмыг Хашаат сумын уугуул, Төрийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн Ц.Доржготовын нэрэмжит болгон зохион байгуулж, орон нутгийн төсвөөс 6.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. 2022, 2023 онуудад зохион байгуулагдсан “Номын сан-100”, “Хангайн цом” яруу найргийн наадмын үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 23.7 сая төгрөгийг зарцууллаа.

Өлзийт сумын Харганын хөндийд Орхон-Тамир, Хануй-Хүнүйн дурсгалыг түшиглэсэн Төв азийн түүх соёлын голомт соёл, аялал жуулчлалын цогцолборын мэдээллийн төвийн барилгыг ашиглалтад оруулсан.

Мөн 2021 оны 02-р сард 18 сумын соёлын төвд Dell inspiron зөөврийн компьютер, Yamaha EMX5 дууны пульт, Epson L3110 өнгөт принтер, JBL JRX225D өсгөгч, MS-240 гэрлийн удирдлага, MS-W54-108 LED пар гэрэл зэрэг 200,0 сая төгрөгний багц тоног төхөөрөмжүүдийг хүлээгэн өгсөн.

Чулуут, Булган, Жаргалант сумдын соёлын төийн барилгын ажил дуусаж үйл ажиллагаа эхэлсэн. Хангай сумын Соёлын төв, спорт заалны их засварын ажил дуусаж үйл ажиллагаа эхэлсэн. 2023 онд Хайрхан, Ихтамир, Төвшрүүлэх, Батцэнгэл сумдын соёлын төвийн барилгад орон нутгийн төсвийн 425,0 сая төгрөгийн санхүүжилтээр их засвар хийлээ.

2021-2024 онуудад улс, орон нутгийн төсөв, хандивын 45,7 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн болон сумдын соёлын төвийн номын сангийн фондыг баяжууллаа. Номын сангийн нийт сан хөмрөгийг 100 хувь электрон каталогит оруулсан. Цахим сан хөмрөг үүсгэх ажил хийгдэж, цахим сан хөмрөгийн эзлэх хувь 0.18 хувьд хүрлээ.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3.1. Санхүү, төсөв:

Төсөв, Санхүүгийн чиглэлээр төлөвлөсөн 5 зорилт 13 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 13 арга хэмжээ 100 хувь, буюу дунджаар 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэх чиглэлээр татварын хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 47 хичээл, татварын тайлан гаргах талаар 138 постер, 337 мэдээ, мэдээллийг татварын хэлтсийн пэйж хуудсанд байршуулан, танхимаар болон цахим хэлбэрээр 263 удаагийн сургалтыг зохион байгуулж, 25283 татвар төлөгч хамрагдлаа.

Татварын байгууллагаас үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээ цахимжуулснаар татварын тайлан, татвар төлөгчийн хүсэлтийг 100 хувь цахим тайлангийн системээр хүлээн авч, татварын тайлан болон хөрөнгийн ногдлоор үүссэн татварыг 100.0 хувь төсөвт төвлөрүүлж, өрийн барагдуулалт 88.6 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 1426 татвар төлөгч 93.3 тэр бум гаруй нэмэгдсэн өртгийн албан татварын баримтыг худалдан авагчид олгосноор борлуулалтын орлого сүүлийн 4 жилд 1.2-2.6 хувиар нэмэгдсэн байна.

Аж ахуй нэгжийн 2021 оны улсын ээлжит тооллогыг зохион байгуулж нийт 1936 аж ахуйн нэгж, байгууллага, 1020 хувиараа хөдөлмөр эрхлэгчийг тооллогод хамруулж, 2022 онд мал аж ахуй, газар тариалан, загас ан агнуур, ойн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 6358 өрх, аж ахуйн нэгж байгууллагыг хөдөө аж ахуйн тооллогод бүрэн хамруулж ажилласан.

Төсвийн ил тод байдал, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах үүднээс шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хууль журмын дагуу үнэн зөв, иж бүрэн байршуулж ажиллах талаар төсөвт албан байгууллагуудад улсын байцаагчийн 15 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар, 27 зөвлөмж хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласнаар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 153 байгууллагын шилэн дансны мэдээлэл байршуулалт, тайлан илгээлт 99.0 хувьтай гарч, шилэн дансны мэдээлэл байршуулалт тогтмолжсон.

Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг олон нийтэд ил тод, нээлттэй, тендер шалгаруулалтыг 100 % цахимаар зохион явуулж, аймаг, суманд хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээг давхардсан тоогоор орон нутгийн 41 аж ахуйн нэгж гэрээ байгуулан ажилласан байна.

Орон нутгийн өмчид бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, орон нутгийн өмчит 167 байгууллагуудтай “Өмч эзэмшлийн гэрээ” байгуулан жил бүр дүгнэн ажиллаж байна. Түүнчлэн ашиглах боломжгүй, илүүдэлтэй хөрөнгүүдийг данс бүртгэлээс хасаж, худалдах, шилжүүлэх, устгах ажлыг зохион байгуулж, орон нутгийн өмчөөс хасаж байгаа хөрөнгийг нийтийн дуудлага худалдаагаар худалдан борлуулж, орон нутгийн төсөвт 358.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор санхүүгийн мэдлэг түгээх 3 удаагийн сургалтаар 110 сургагч багшийг бэлтгэж бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн төв, 18 суманд давхардсан тоогоор 15000 орчим сурагч, 7200 иргэнд сургалт, мэдээ мэдээлэл хийсэн ба цахим орчноор 83000 гаруй иргэн мэдээлэлтэй танилцсан байна.

Монгол банк, арилжааны банкны салбарууд, Хадгаламжийн даатгалын корпораци хамтран “Дэлхийн хуримтлалын өдөр”, “Дэлхийн мөнгөний 7 хоног” аянуудыг жил бүр амжилттай зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд 2024 оны 10 дугаар сарын байдлаар 54,776 иргэн, аж ахуйн нэгжийн 207.4 тэрбум төгрөгийн хугацаатай болон хугацаагүй хадгаламжтай байна. Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 28 хувиар буюу 45.3 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлтэй байна.

Цахим луйвар, залилангаас урьдчилан сэргийлэх, мөнгөн тэмдэгтийн нууцлал, Монгол Улсын эдийн засгийн судалгааны чиглэл, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээрх нийт 16 төрлийн гарын авлагыг 8000 ширхгийг тарааж, санхүүгийн боловсрол олгох 800 орчим төрлийн мэдээ, мэдээллийг аймгийн цахим орчноор дамжуулан иргэд, олон нийтэд хүргэж ажиллалаа.

3.2. Хөдөө аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ:

Хөдөө аж ахуй, үйлдвэр үйлчилгээний чиглэлээр төлөвлөсөн 19 зорилт 39 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 33 арга хэмжээ 100 хувь, 4 арга хэмжээ 90 хувь, 2 арга хэмжээ 70 хувь буюу дунджаар 97,4 хувийн гүйцэтгэлтэй байна.

2021 онд “Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд 14 ширхэг 80-аас дээш морины хүчтэй трактор, бусад дагалдах хэрэгсэл бүхий техник үйлчилгээний төв байгуулагдсан. 2022-2023 онд тус төвийн техник хэрэгслийг “Малын ногоон тэжээл тариалах” төслийн хүрээнд үр тарианы комбайн 1, борной, анжис тус тус 2 ширхэгийг хүлээлгэн өгч нэмэгдүүллээ. Тус төв нь техникгүй иргэдэд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан үнэ тарифын дагуу техник, хэрэгслийг түрээсээр ашиглуулж байна.

2021-2024 онд улс, орон нутаг, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 101 инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргаж, 2010 өрхийн 232.5 мянган толгой мал, 263,5 мянга га бэлчээрийг усжуулсан нь бэлчээрийн усан хангамжийг 10 гаруй хувиар нэмэгдүүлсэн байна. Үлийн цагаан оготно ихээр тархсан 230,3 мянга га бэлчээрт энгийн механик болон микробиологийн аргаар тэмцэх ажлыг зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд 11 сумын 14 мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжид 3995 толгой бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлсэн нь нийт бог малын хээлтүүлэгчийн 26.5 хувийг эзэлж байгаа бөгөөд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 70.2 мянган толгой малд үзлэг ангилалт хийж, цөм сүрэг бүрдүүлсэн байна.

2022-2024 онуудад хэрэгжсэн “Шинэ хөдөө”, “Малын үүлдэр угсааг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Хотонт үржлийн хэсгийн 816 толгой хээлтэгч, хээлтүүлэгч, Сүү-махны чиглэлийн хосолмол ашиг шимтэй “Монбелиард” үүлдрийн 29 толгой үхэр, “Алатау” үүлдрийн 31 толгой үхрийг авч, сонгон шалгаруулалтын зарчмаар сонгогдсон 6 аж ахуйн нэгжид 5 жилийн хугацаатай эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээгээр хүлээлгэн өгч, үйл ажиллагааг нь дэмжин ажиллалаа.

Мөн Улсын төсвийн хөрөнгөөр 2021, 2022, 2024 онд нийлүүлэгдсэн Сэлэнгэ үүлдрийн 905 толгой үхрийг 17 аж ахуйн нэгжид 5 жилийн хугацаатай гэрээ байгуулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олголоо.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Эрдэнэбулган, Булган суманд мал нядалгааны цэг байгуулаад байна.

2024 онд 15446 га талбайд тариалалт хийж 22609 тн ургац хураан авсан нь 2020 онтой харьцуулахад тариалсан талбай 25 хувиар, хураасан ургац 22 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд 132 ширхэг 3081 тн – ын багтаамж бүхий төмс, хүнсний ногооны зорь ашиглагдаж байгаа бөгөөд 2020 онтой харьцуулахад багтаамж нь 276 тн буюу 9.8 хувиар нэмэгдсэн.

Өрхийн тариалан арга хэмжээг хэрэгжүүлснээр 130.8 сая төгрөгийн үнэ бүхий 60.7 тн хүнсний ногооны үрийг ХХААХҮЯ-аас 80 хувийн хөнгөлөлттэй үнээр олгож, 19 сумын 1180 өрхөд хувиарлан өгч тариалалт хийлээ. Аймгийн хэмжээнд 2024 онд 241 га-д төмс тариалж, 2269 тн ургац, 125 га-д хүнсний ногоо тариалж, 1105 тн ургац тус тус хураан авсан нь дотоодын хэрэгцээний 70 хувийг хангаж байна.

2024 онд дотрын халдварт хордлого, цусан халдварт, дуут хавдар, листериоз, шөвөг яр, боом, галзуу, шүлхий, хонины цэцэг, бруцеллёз, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 7215,7 мянган толгой мал, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 5735,4 мянган толгой малыг хамруулсан.

2021-2024 онуудад мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд сурталчлан таниулах, борлуулах, түншлэл тогтоох, мэдээлэл, арга барил, туршлагаа харилцан солилцох боломж нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Архангай түншлэл” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Тус үзэсгэлэн худалдаанд аймгийн сумдаас гадна Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Сүхбаатар, Булган аймгуудын нийт давхардсан тоогоор 140 аж ахуй нэгж, иргэд төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурилан бүтээгдэхүүн, модон эдлэл, бэлэн хувцас, гар урлалын бүтээгдэхүүн, гэр ахуйн цахилгаан бараа, эсгий ноосон бүтээгдэхүүн, барилгын материал зэрэг 40 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаалж, 2021 онд 116.9 сая.төг, 2022 онд 117.6 сая.төг, 2023 онд 135.9 сая.төг, 2024 онд 203.3 сая.төгрөгийн борлуулалт хийсэн байна.

“Малчин эмэгтэйчүүд ба аюулгүй хүнс” хөтөлбөрийн хүрээнд Ихтамир, Тариат, Булган сумдын 340 гаруй малчин эмэгтэйчүүдэд малчдын хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, ахуйн зориулалтаар ашиглахгүй байх, зориулалтын бус савны хор холбогдлын талаарх сургалтуудыг зохион байгуулсан. Мөн Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Ихтамир, Төвшрүүлэх, Хотонт, Өгийнуур, Хашаат сумуудын 60 өрхөд “Чиглэл” ХХК-ны 7 нэр төрлийн сав суулгыг

олгож “ЭКО САВТАЙ ӨРХ” гэрчилгээ олголоо.

“Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2021-2024 онд сүү, цагаан идээ, хүнсний үйлдвэрлэл, гахайн аж ахуй, мод модон эдлэл, газар тариалан, оёдол, арьсан эдлэл, мод үрсэлгээ, хүлэмжийн чиглэлийн 16 төсөлд 2 тэрбум 250,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 61 ажлын байр шинээр бий болсон байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд 19 сумын 322 иргэн, аж ахуйн нэгж, хоршоод хамрагдаж 5,4 тэрбум төгрөгийн зээлийг олгосноор 980 ажлын байр бий болсон байна. Мөн "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд аймгийн хэмжээнд 590 хоршоо шинээр байгуулагдаж, 354 хоршооны 1705 малчинд 45.8 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна.

3.3. Тогтвортой аялал, жуулчлал:

Тогтвортой аялал, жуулчлалын чиглэлээр төлөвлөсөн 7 зорилт 9 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 7 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээ 90 хувь, 1 арга хэмжээ 70 хувь буюу дунджаар 95,5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн аялал жуулчлалыг 2023-2032 онд хөгжүүлэх бодлогын цогц баримт бичгийн хүрээнд 2024 онд аймгийн Засаг даргаас Эртний нүүдэлчдийн өлгий аймгийн аялал жуулчлалын холбоотой хамтран ажиллах 16 заалт бүхий төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж, бодлогын баримт бичгийн хэрэгжилт 20%-тай гүйцэтгэлээ.

Соёлын биет бус өв болсон Монголын түүхт өвлийн спортуудыг дэлхийд сурталчлах, өвлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор Монголын анхны өвсөн стадион барьж WINTERLAND ICE FESTIVAL-ыг зохион байгууллаа. 2023-2024 онуудад дээрх арга хэмжээнд 45.000 хүн оролцлоо.

Аймгийн аялал жуулчлалын холбоотой хамтран “Малчин кемп” төслийг 2024 онд ажилттай хэрэгжүүлж эхлэлээ. 8 сумын 30 байршлын 60 малчин айлыг хамруулж, төсөлд хамрагдсан айл бүрийг эко хуурай 00-оор хангаж, эдгээр айлууд нь visit ARA хөтөлбөрөөр болон хувийн шугамаар гэсэн 2 төрлөөр аялагчдын захиалгыг авсан ба 2024 оны 7 сард visit ARA Хөтөлбөрөөр дамжуулан 10,147,500 төгрөгийн захиалга хүлээн авсан байна.

Аялал жуулчлалын идэвхтэй 60 хоног амрагч хүлээж авахаас дээд тал нь 20 хоногт нь амрагч хүлээн авсан үр дүнтэй ажиллалаа. 7, 8 дугаар сард 1026 хүн гэр кемпээр үйлчлүүлж, 256 гэр захиалсан байна.

Архангай аймагт 2020-2024 онд гадаад болон дотоодын 918.893 жуулчин, аялагч ирсэн байна.

2024 онд Архангай аймгийг зорьсон зөвхөн дотоодын аялагчдын тоог 2023 оныхтой харьцуулахад 39%-ийн өсөлттэй гарсан байна.

"ITM-2023" олон улсын үзэсгэлэнд 1 тур оператор, 28 жуулчны бааз, 3 зочид буудлын бүрэлдэхүүнтэйгээр оролцож, тогтмолжсон 4 эвент арга хэмжээ, тойрон аяллын 30 маршрут, 2024 онд АРА комплекст зохион байгуулагдах 21 арга хэмжээг танилцуулж үүний дүнд аж ахуй нэгжүүд 280 орчим урьдчилсан захилгыг авч, гэрээ байгуулаад байна.

3.4. Барилга, хот байгуулалт:

Барилга, хот байгуулалтын чиглэлээр төлөвлөсөн 7 зорилт 13 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 8 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээ 90 хувь, 1 арга хэмжээ 70 хувь, 3 арга хэмжээ 30 хувь буюу дунджаар 83,8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн төвийн иргэдийн ая тухтай аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай нийтийн эзэмшлийн гудамж, талбай, зам дагуу байрлах гэрэлтүүлгийг аймгийн Хот тохижилт, үйлчилгээний газар хариуцан улиралд тохируулан асааж, график төлөвлөгөөний дагуу гэмтэл гарсан тухай бүрд засварлаж, асахгүй байгаа гэрэл, гэрлийн толгойг шинээр сольж ажиллаж байна. Мөн Орон нутгийн хөгжлийн сангийн 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1, 2, 3, 4, 5, 7 дугаар багуудад 35 ширхэг гэрэлт цамхаг хийгдсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн 200 сая төгрөгөөр аймгийн төвийн иргэд болон баруун аймгууд руу зорчигчид, гадаад дотоодын аялагчдыг цэвэр усаар хангах бүрэн боломжтой 24/7 буюу өдөр, шөнө тасралтгүй цэвэршүүлсэн усаар үйлчлэх хүчин чадалтай авто худаг буюу цэвэр усны төв байгуулагдлаа.

2023 онд Аймгийн түүхт 100 жилийн ойн ажлын хүрээнд аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Цэцэрлэг хотод Багц-1: Гэрэлтүүлгийн ажил 500 сая төгрөг, Багц-2: Төв талбай орчмын тохижилт /индер, гэрэлт гудамж, усан оргилуур, Архангай -90 самбарыг Архангай-100 болгох, талбай орчмын гэрэлтүүлэг/ -300 сая төгрөг, Багц-3: Архангай -100 логог Улсын чанартай авто зам дагуух гэрэлтүүлгийн шонд байрлуулах - 22 сая төгрөгийн ажлууд хийгдсэн.

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын материалын лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, багаж тоног төхөөрөмжийг шинэчиллээ.

Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтцийн ажлын хүрээнд 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад санхүүжихээр тусгагдсан 6.387 тэрбум төгрөгөөр улсын чанартай авто зам дагуу 7 км гэрэлтүүлгийн ажил, 7.8 км явган зам шинээр тавих ажил, хуучны 39 орон сууцны гадна фасад, дээвэр засварлах ажил хийгдэж байна.

Багшийн хөгжил, судалгааны арга зүйн төв, аймгийн Нутгийн захиргааны ордны өргөтгөл засвар, Хайрханд үйлдвэрлэв худалдааны төв, Сарлагийн музей, нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын судалгааны төв, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар шинэчлэл, Тамир хүүхдийн зусланг олон улсын хүүхдийн зуслан болгох цогцолбор барилгын зураг төсөл зэрэг нийт 40-өөд ажлын зураг төслийг хийлгээд байна.

2020-2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд Эрдэнэбулган суманд 300 ортой эмнэлгийн барилга, Усан бассейны барилга, Багшийн хөгжил, судалгааны төв (инновацийн төв), Прокурорын барилга, 200 хүүхдийн хүчин чадалтай II цэцэрлэгийн барилга, IV сургуулийн өргөтгөлийн барилга, Булган, Чулуут, Жаргалант сумдын 240 хүний суудалтай Соёлын төв, Чулуутын 320 хүүхдийн суудалтай сургууль, Төвшрүүлэх, Батцэнгэл, Хотонт,

Жаргалант сумдын 150 ортой цэцэрлэгийн барилга, Цэцэрлэг сумын 50 хүүхдийн ортой цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, Хашаат сумын сургуулийн өргөтгөлийн барилга, Эрдэнэмандал сумын “Сумын төвийн шинэчлэл”, Ихтамир, Цахир сумдын 10 ортой эмнэлгийн өргөтгөлийн томоохон барилгууд байнгын ашиглалтад ороод байна.

Орон нутагт шаардлагатай байгаа төрийн суурь үйлчилгээний барилга байгууламжуудын судалгааг мэргэжлийн байгууллагаас мэргэжилтнүүд сумуудаар газар дээр очин үзэж, шинээр барих, их засвар, урсгал засвар хийх шаардлагатай барилга байгууламжуудыг эрэмбэлэн 2024 онд их засвар хийх барилга байгууламжуудын техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг үе шаттайгаар боловсруулан ажиллаж байна.

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1. Цахим Архангай-төрийн шуурхай үйлчилгээ:

Цахим Архангай – төрийн шуурхай үйлчилгээний чиглэлээр төлөвлөсөн 12 зорилт 27 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 16 арга хэмжээ 100 хувь, 5 арга хэмжээ 90 хувь, 4 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 50 хувь, 1 арга хэмжээ 0 хувь буюу дунджаар 88,1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 499 дүгээр тогтоолоор Архангай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг 5 хүний орон тоотойгоор шинээр байгуулагдсан бөгөөд Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, аймгийн нэгдсэн эмнэлэг, Монгол шуудангийн салбар гэсэн 4 байршилд “Хурдан” цэгийг нээж, иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлж байна.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн “Цахим Монгол-төрийн шуурхай үйлчилгээ” зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн үйлчилгээний цахим системд 43 байгууллагын 23 оператор ажилтнаар дамжуулан хүн, хуулийн этгээдэд 790 үйлчилгээг цахимаар үзүүлж байна. Дээрх ажлын хүрээнд төрийн байгууллагын 1472 албан хаагч, 740 иргэд, жижиг дунд бизнэс эрхлэгчид, 1344 ЕБС-ийн багш, сурагчид олон нийт болон сумдын төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн ажилтнуудад 3 шатны цахим болон танхимын сургалтыг тус тус зохион байгуулсан байна.

4.2. Мэргэшсэн хариуцлагатай төрийн алба:

Мэргэшсэн, хариуцлагатай төрийн албаны чиглэлээр төлөвлөсөн 8 зорилт 19 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 18 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээ 0 хувь буюу дунджаар 94,7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төрийн албаны ерөнхий, тусгай шалгалтын болон төрийн захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах, төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журмуудыг нэгтгэн шинэчлэн батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын хүрээнд төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг зохион байгуулж байна.

Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх зорилгоор төрийн албаны ерөнхий шалгалтыг 2021 онд 2 удаа зохион байгуулж 559 иргэн бүртгүүлж, 460 иргэн шалгалтад орж, оролцсон иргэдийн 28.9 хувь буюу 133 иргэн тэнцсэн, 2022 онд 2 удаа зохион байгуулж 389 иргэн бүртгүүлж, 332 иргэн шалгалтад орж, оролцсон иргэдийн 35.5 хувь буюу 118, 2023 онд 4 удаа зохион байгуулж 470 иргэн бүртгүүлснээс 365 иргэн шалгалтад орж, оролцогчдын 43.2 хувь буюу 158 иргэн, 2024 онд 4 удаа зохион байгуулж 437 иргэн бүртгүүлснээс 350 иргэн шалгалтад орж, оролцогчдын 36.5 хувь буюу 128 иргэн тус тус тэнцэж, ерөнхий шалгалтыг 12 удаа зохион байгуулахад нийт 1855 иргэн бүртгүүлж, үүнээс 1507 иргэн шалгалтад орж, шалгалтад орсон иргэдийн 35.6 хувь буюу 537 иргэн тэнцэж төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн байна.

Томилох эрх бүхий албан тушаалтнаас Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлд ирүүлсэн захиалгын дагуу төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагч, бүтцийн нэгжийн удирдах албан тушаал, төрийн захиргааны дэс дүшмэл, туслах түшмэлийн албан тушаалын сул орон тооны тусгай шалгалтыг тухай бүр зохион байгуулж хэвшсэн байна. Тухайлбал,

Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтыг 2021 онд 3 удаа зохион байгуулж, 142 сул орон тоо зарлан, 69 сул орон тоог нөхсөн, 2022 онд 2 удаа зохион байгуулж, 257 сул орон тоо зарлан, 99 сул орон тоог нөхсөн, 2023 онд 3 удаа зохион байгуулж, 313 сул орон тоо зарлан, 82 сул орон тоог нөхсөн, 2024 онд 3 удаа зохион байгуулж, 243 сул орон тоо зарлан, 72 орон тоог нөхсөн.

2021-2024 онд төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтыг хууль журмын дагуу 11 удаа зохион байгуулж нийт 955 сул орон тоог зарлан, зарласан орон тооны 33.7 хувийг буюу 322 сул орон тоог нөхсөн дүнтэй байна.

Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалтыг 2021 онд 1 удаа зохион байгуулж, 3 сул орон тоо зарлан, 1 сул орон тоог нөхсөн, 2022 онд 2 удаа зохион байгуулж, 15 сул орон тоо зарлан, 7 сул орон тоог нөхсөн, 2023 онд 3 удаа зохион байгуулж, 40 сул орон тоо зарлан, 20 сул орон тоог нөхсөн.

2021-2024 онд төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн албан тушаалын сонгон шалгаруулалтыг хууль журмын дагуу 6 удаа зохион байгуулж нийт 58 сул орон тоог зарлан, зарласан орон тооны 48.2 хувийг буюу 28 сул орон тоог нөхсөн үзүүлэлттэй байна.

Удирдлагын Академийн төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтуудад албан хаагчдыг үе шаттай хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авч байна.

2021- 2024 онд Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 6, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 43, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 47, Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 37, чиглүүлэх богино хугацааны

сургалтад 12 төрийн албан хаагч тус тус хамрагдаж, Удирдлагын Академийн төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад нийт 155 албан хаагч хамрагдаж төгссөн байна.

Төрийн албаны тухай хуульд төрийн албанд ур чадварын шилжилт хийх, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр нэмэлт өөрчлөлт орж, төрийн албан тушаалын ангилал хооронд ур чадварын шилжилт хийх боломж бүрдсэн. Энэ хүрээнд төрийн улс төрийн албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргааны зохих ангилалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцох, төрийн тусгай болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргааны албан тушаалын зохих ангилалд ажилласан хугацаанд адилтган авч үзэх журам, жагсаалт гаргаснаар төрийн албаны ангилал хооронд сэлгэх, шилжүүлэх, ажилтны ур чадварыг ашиглах замаар хүний нөөцийн нөхөн хангалтыг тэлэх боломж нөхцөл бүрдэж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, аймаг, сумын Засаг даргын тамгын газар, сумын төсөвт байгууллагууд зэрэг 150 гаруй төрийн байгууллага Ёс зүйн дэд хороо байгуулан, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийг арга зүйн удирдлагаар хангаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар заавар зөвлөмж өгөх хүрээнд аймгийн ЗДТГ, Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөл хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүй, гүйцэтгэлийн удирдлага” сэдэвт чадавхжуулах сургалтыг 2023 онд зохион байгуулж сумдын 200 орчим төрийн албан хаагчийг цахимаар, танхимаар 120, нийт 320 албан хаагчийг хамруулж, 2024 онд “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хууль хэрэглээ” сэдвээр 5 байгууллагын 120 албан хаагчид сургалт зохион байгуулж мэдээлэл өгсөн.

4.3. Амар тайван, аюулгүй нийгэм:

Амар тайван, аюулгүй нийгмийн чиглэлээр төлөвлөсөн 10 зорилт 29 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 17 арга хэмжээ 100 хувь, 6 арга хэмжээ 90 хувь, 5 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 30 хувь, буюу дунджаар 90,3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн газраас нэгдсэн 15 төрлийн арга хэмжээ, хэсэгчилсэн 8 төрлийн арга хэмжээг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулахаар төлөвлөн ажилласан байна.

Төлөвлөгөөний хүрээнд гэр бүлийн хүчирхийллийг бууруулах зорилгоор “Аз жаргалтай гэр бүл” хүүхдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор “Замын хөдөлгөөний цагаан толгой”, “Өсвөрийн сэргийлэгч”, “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй”, “Хонх”, “Хүүхэд хамгаалал 2024”, “Нуугдмал” архи согтууруулах ундааны хэрэглээ, хуурамч архитай тэмцэх зорилгоор “Цахим архи”, байгалиа хамгаалах зорилгоор “Тэрбум мод”, “Байгалиа хамгаалъя”, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, оргодол, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдүүдийг олох зорилгоор “Цагаан сар”, “Нөөц”, Хар тамхи мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх

“Анзаар”, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор “Мэдэгдэл”, “Зам, замын байгууламж”, “Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн байдал”, “Шугам зам, хар цэг” зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллалаа.

Архангай аймгийн “Теле камерын хяналтын дэд төв”, “Серверийн өрөө”-г Цагдаагийн газрын одоогийн барилгад байгуулж стандартад нийцүүлэн нийт 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр, засвар, урд ашиглаж байсан тоног төхөөрөмжүүдийн хүчин чадлыг сайжруулах, дүрс бичлэг хадгалах төхөөрөмж нэмэгдүүлэх, хөргөлтийн систем /Condition/ байршуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн “Теле камерын хяналтын дэд төв”-ийг ашиглалтад бүрэн оруулсан.

Камерын бүртгэлийн санд энэ оны 10 дугаар сарын байдлаар 922 иргэн, аж ахуйн нэгжийн 1050 камер, 565 анхааруулах тэмдэг, нийт 1615 мэдээлэл орон нутгийн зардлаар хийгдсэн хөдөлгөөнт 72, чиглэлийн 386 камер, 366 анхааруулах тэмдгийн тус тус оруулж, хүрэх түвшинг 100 хувиас илүү гарган ажилласан.

“Теле камерын хяналтын дэд төв”-д холбогдсон гудамж талбайд байрших телехяналтын камеруудын гэмтлийг засварлах, шинэчлэх, иргэн, аж ахуй нэгжүүдийн гадна талбайг харуулсан телехяналтын камеруудыг холбох ажлыг хийж гүйцэтгэн, аймгийн төвд орон нутгийн хөрөнгөөр суурилуулсан 54 цэгийн 154 камер, аж ахуй нэгжийн гудамж талбайг харуулсан 28 цэгийн 34 телехяналтын камерыг дэд төвд холбож, 24 цагаар хяналт тавин ажиллаж байна.

“Ногоон бүс” төслийн хүрээнд Архангай аймгаас Улаанбаатар чиглэлийн төв магистрал замд дундаж хурд хэмжих камер байршуулахад 135.0 сая, аймгийн төвийн нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайг камержуулах 170.0 сая, нийт 305.0 сая төгрөгийг төсөвлөсөн бөгөөд тендерийг зарлан сонгон шалгаруулж, камержуулах ажил хийгдэж байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Хотонт, Цахир, Жаргалант сумын хөдөлгөөний ачаалал ихтэй цэг, гүүрэн гарц, орох, гарах зам зэрэг газруудад нийт 17 гэрэлт цамхаг, 21 хөдөлгөөнт, 25 чиглэлд шаардлага хангасан теле камеруудыг байршуулан үйл ажиллагаандаа ашигласан байна.

ТАВ: НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1. Байгаль орчны чиглэлээр:

Байгал орчны чиглэлээр төлөвлөсөн 12 зорилт 20 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 16 арга хэмжээ 100 хувь, 4 арга хэмжээ 70 хувь, буюу дунджаар 94 хувийн гүйцэтгэлтэй байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний 9 зорилтын арга хэмжээг зохион байгуулж нийт 1120263 мод, бут, сөөг тарьж, төв суурин газрын ногоон

байгууламжийн хэмжээ 2020 оны суурь түшингээс 80 га-р нэмэгдэж нийт 190,7 га болж нэмэгдлээ.

Цэнхэр, Булган, Ихтамир суман дахь Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн хүлэмжид 250 кг үрээр тарилт хийж 50 мянган тарьц, суулгацын нөөц бүрдүүллээ. Мөн Өгийнуур, Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Хотонт, Хайрхан, Цэнхэр, Ихтамир зэрэг сумдын мод үржүүлгийн хувийн аж ахуй нэгжүүд талбайдаа тарьц, суулгацын нөөц бүрдүүлэхээр хүлэмж болон ил талбайд навчит, шилмүүст модны 80 кг үр, 200.0 мянга гаруй мөчрөөр тарилт хийж усалгаа, арчилгааны ажлыг технологийн дагуу хийж гүйцэтгүүллээ.

Мод үржүүлгийн газруудын талбайд 1-5 настай 10 гаруй төрөл зүйлийн 500 мянган ширхэг тарьц суулгацын нөөцийг бүрдүүлж ажиллалаа.

“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд ойн түймэр, хөнөөлт шавж, өвчний нөлөөлөл, хууль бус мод бэлтгэлийн улмаас доройтсон ойг нөхөн сэргээх зорилгоор Ихтамир, Цэнхэр, Жаргалант, Булган, Хангай сумуудад улсын болон орон нутгийн 354 сая төгрөгөөр 286 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Ойн хөнөөлт шавж, өвчний судалгааны ажлыг жилд 2 удаагийн давтамжаар 400.0-510.0 мян.га талбайд гүйцэтгүүллээ. Ой, модыг хамгаалах, хөнөөлт шавжийн хэт олшролыг бууруулах зорилгоор тэдгээртэй тэмцэх ажлыг улс, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн 11.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 180.0 мянган га талбайд хийлээ.

Аймгийн засаг даргын 2024 оны А/244 дугаар захирамжийн дагуу байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас усны тоо бүртгэлийн ажлыг 19 суманд зохион байгуулж мэдээллийн санг шинэчиллээ. Тус тооллогоор 995 гол горхи, 1005 булаг шанд, 232 нуур, 45 рашаан, 374-н ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж бүртгэгдсэн байна.

Өгийнуур, Булган, Цэнхэр, Чулуут, Хайрхан, Батцэнгэл, Ихтамир, Хашаат сумдын нутагт 481 толгой тарвага, Булган, Тариат сумдын нутагт 9 толгой ойн зэрлэг гахай, Бөхөн шарын нуруунд Баданга хүдэр 7, бугын илий 20, Чулуут голын сав газарт 2.005.000 ширхэг Зэвэг, хадрангийн жарамгай, Эрдэнэбулган суманд 29 толгой Янгирыг шинээр болон сэргээн нутагшууллаа. Ховор болон нэн ховор амьтны тархалт бүхий бүс нутгуудад 55 удаагийн биотехникийн арга 27.1 тонн өвс, тэжээл, 11.2 тонн хужир мараагаар биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

2020-2024 онд уул уурхайн олборлолтын улмаас үүдэж эвдэрсэн 87.55 га талбайд техникийн, 53 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгүүллээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар тогтоолоор Хайрхан, Батцэнгэл, Эрдэнэмандал сумын нутгийн зарим хэсгийг хамарсан Бөхөн шарын нурууны 58.167 га газрыг байгалийн унаган төрхийг хамгаалах ангиллаар, Өндөр-Улаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04 дүгээр тогтоолоор Шаргачны гол орчмын 32800 га талбайг, Ихтамир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 01 дүгээр тогтоолоор Ихтамир сумын Эрдэнэтолгой, Хан-Өндөр Багийн нутагт байрлах Нарийн өлөнт, Их өлөнт, Алтан, Иххужир зэрэг газруудын тодорхой зааг бүхий 7093.6 га талбайг “Ой, амьтан, ургамал, усны” нөөц газрын ангилалд орон нутгийн хамгаалалтад авснаар орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хэмжээ 737135.07 га болж орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хэмжээ 13.32 хувьд хүрлээ.

Цэцэрлэг хотын угтах хэсгийн өнгө үзэмжийг сайжруулах, иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчныг сайжруулахад аймгийн нэгдсэн хогийн цэгт төвлөрсөн хогийн хур буюу 76.000 м³ овоолгыг хэлбэржүүлж, байгалийн хөрсөөр хучих, 200х100м³ харьцаатай хог хаягдлын сан байгуулах ажлыг зохион байгуулаад байна.

Хур хогийг ландфиллийн аргаар дарж, хог хаягдлын сан байгуулснаар цэцэрлэг хотын иргэд багадаа 30-40 жилийн хугацаанд ашиглах боломжтой хог хаягдлын санг шинээр байгуулаад байна.

“Ойгоос хэрэглээний болон галын түлээний мод бэлтгэх дээд хэмжээг тогтоох тухай” аймаг, сумдын ИТХ-ын тогтоолуудыг үндэслэн ойн хөнөөлт шавж, түймэр, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр цаашид ургах чадваргүй болж үхэжсэн, унасан, хатсан модыг цэвэрлүүлэх, ойн санг эрүүлжүүлж, төлөв байдлыг сайжруулах зорилгоор 15 сумын ойн сангийн 192 га талбайд унанги болон хатсан модны нөөц тогтоох талбай тусгаарлалтын ажлыг Сум дундын ойн ангиудаар гүйцэтгүүлээд байна. Энэ хугацаанд 53,996.33 м³ хэрэглээний мод, түлээг иргэд аж ахуйн нэгж, байгууллагаар технологийн дагуу бэлтгүүлээд байна.

Аймгийн хэмжээнд ойн хөнөөлт шавж, өвчний хаврын судалгааны ажлыг ойн сан бүхий 14 сумын 510.0 мянган га талбайд хийж гүйцэтгэж, ойн хөнөөлт шавжийн тархалттай болон голомттой талбайн хэмжээг бууруулах, ойн байгалийн сэргэн ургалт, өсөлт, хөгжилтийг хангах зорилгоор тэмцлийн ажлыг 59,385 га талбайд хийхээр төлөвлөснөөс ажлын гүйцэтгэлээр 61,675 га талбайд зохион байгууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг газраар үүргэн шүршигч багаж ашиглан химийн аргаар Батцэнгэл, Өлзийт сумдын ойн санд 2000 га талбайд, авиа микробиологийн аргаар буюу агаарын хөлөг ашиглан Хотонт, Төвшрүүлэх, Цэнхэр, Булган сумдын ойн санд 40.000 га талбайд гүйцэтгүүлээ.

Харин орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Булган, Ихтамир, Жаргалант, Тариат, Цэнхэр, Цэцэрлэг, Хотонт, Чулуут сумдын ойн санд 19,675 га талбайд гүйцэтгүүлж, тэмцлийн ажлын техникийн үр дүнд орон нутгийн Ойн анги, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид хяналт тавьж ажиллалаа.

Архангай аймгийн 19-н суманд ус бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллогын ажлыг зохион байгууллаа. Нийт 574 ус бохирдуулагч эх үүсвэр тоологдсон байна.

Батцэнгэл, Хайрхан сумдад Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төслөөс Эрдэнэмандал сумын Урт шивэртэд бугын 10 элий, Булган сум байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 100, Батцэнгэл сум 20, нийт 160 тоо толгой тарвагыг сэргээн нутагшууллаа.

Чулуут голын сав газарт “Чулуут тул” ТББ 300.0 мянга хадрангийн жарамгай, 200.0 мянга орчим зэвгийн жарамгай нийт 500.0 мянга орчим бие даан амьдрах чадвартай жарамгайг Чулуут голд нутагшууллаа.

Архангай аймгийн төгсөгчдийн санаачилгаар Булган уулын дурсгалт газарт 3 эр, 9 эм янгирыг 1 ишигний хамт нутагшуулан байнгын хяналт, мониторингийн ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Цахир сумын Эх алаг баяндаргай агнуурын бүсэд биотехникийн арга хэмжээг Цахир сумын нутаг Дөрөө хангинах, Эргэлзээт, Хөх уул зэрэг газарт 50 боодол өвс,

300 кг хужир мараа, Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төслөөс Бөхөн шарын нурууны орон нутгийн тусгай хамгаалалттай газарт хамгаалалтын үнэт зүйл болох Хүдэрт 3 удаагийн биотехникийн арга хэмжээг 4.5 м³ хушны хагаар, Хашаат сумын Номгон ууланд Хашаат сумын ЗДТГ, Их номгон нөхөрлөл хамтран 12 боодол өвс, 200 кг хужир мараагаар, Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас 9 цэгт 1640 кг хужир, 40 боодол өвсөөр биотехникийн арга хэмжээ авч ажиллалаа.

Цэнхэр сумын Орхон багт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “БМНС” ХХК-аар өөрийн тусгай зөвшөөрлийн 8 га талбайд биологийн, “Батдөлгөөн мөрөн” ХХК-аар 8 га талбайд техникийн, Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Бодь-Ар” ХХК-аар дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 1 га талбайд техникийн, “Ашид бэхи” ХХК-аар тусгай зөвшөөрлийнх нь 1 га-д техникийн, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 2.2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг тус тус хийж гүйцэтгүүлээд байна.

ЗУРГАА.БҮС ОРОН НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ

6.1. Бүс орон нутаг, хөдөөгийн хөгжил, дэд бүтэц:

Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, дэд бүтцийн чиглэлээр төлөвлөсөн 11 зорилт 20 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 12 арга хэмжээ 100 хувь, 3 арга хэмжээ 90 хувь, 4 арга хэмжээ 70 хувь, арга хэмжээ 0 хувь буюу дунджаар 87,5 хувийн гүйцэтгэлтэй байна.

БНСУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжих Дулааны станцын техник эдийн засгийн үндэслэл болон зураг төсөл бүрэн боловсруулагдаж дууссан ч төсөл хэрэгжүүлэх явцад аймгийн төв Цэцэрлэг хотын дулаан хангамжийн үйлчилгээг хариуцан ажилладаг “Эх голомтын илч” ХХК-ийн Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргасантай холбоотойгоор шүүхийн асуудал шийдэгдтэл, төслийн ажлын төсвийг нь тусгаарлан, гүйцэтгэгч шалгаруулах тендерийн ажлыг түр хугацаанд зогсоогоод байсан бол Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс болон Монгол улсын дээд шүүхээс “Эх голомтын илч” ХХК-ийн гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэснээр Архангай аймагт төсөл үргэлжлэн хэрэгжих нөхцөл боломж бүрдсэн.

2024 онд улсын төсвийн санхүүжилтээр аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц /Архангай, Эрдэнэбулган сум/-ийн ажил эхэлж цахилгаан хангамжийн 14 станц баригдаад байна.

Хөдөөгийн алслагдсан 5 багийг холбоожуулах, 4G сүлжээ нэвтрүүлэх ажлын гүйцэтгэгчээр “Цагаан сүмбэр” ХХК шалгаран 80 хувийн гүйцэтгэлтэй байна. Оndoо багтаан хүлээлгэн өгнө.

Хөдөөгийн алслагдсан 5 багийн төвд 30-45 кВт хүчин чадалтай нарны цахилгаан станц суурьлуулах ажлын гүйцэтгэгчээр “Жи пауэр” ХХК шалгаран барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөөд байна

Шаардлагатай зарим сумдын аялал жуулчлалын бүс нутаг болон шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчинд холбох ажлын хүрээнд 2023 онд 2 аялал жуулчлалын бүс, 1 шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчинд

холбосон. Мөн 2024 онд Эрчим хүчний сайдын багцаас Сумын төвийн цахилгаан хангамжийн өргөтгөл, шинэчлэлт (Архангай, Ихтамир сум) ажлыг 144,3 сая төгрөгөөр, Сумын төвийн цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамж (Архангай, Цэцэрлэг, Хашаат сумд) ажлыг 303,7 сая төгрөгөөр хэрэгжүүлж байнгын ашиглалтад хүлээн авсан байна.

Аймгийн төв Эрдэнэбулган суманд одоогийн байдлаар 1884 айл, айл өрх инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдарч байна. 2021 онд 37 айл, 2022 онд 179 айл, 2023 онд 175 айлын орон сууц ашиглалтад орсон. 2024 онд 200 айлын орон сууц ашиглалтад орохоор баригдаж байна.

Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтцийн ажлын хүрээнд 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад санхүүжихээр тусгагдсан 6.387 тэрбум төгрөгөөр улсын чанартай авто зам дагуу 7 км гэрэлтүүлгийн ажил, 7.8 км явган зам шинээр тавих ажил, хуучны 39 орон сууцны гадна фасад, дээвэр засварлах ажил хийгдэж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Тариат сумын төв доторх хатуу хучилттай авто замын ажил, Тариат сумын Мөрөн багийн Суман голын 35 у/м төмөр бетон гүүрний ажил, Хангай сумын төв доторх хатуу хучилттай авто замын ажил, Хархорин-Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Өгийнуур-Батцэнгэл-Ихтамир чиглэлийн А27 дугаартай мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто зам хүртэлх авто замын ажлын эхлэл хэсэг 14 км, Өндөр-Улаан сумын төвийн 7 км хатуу хучилттай авто зам, Хайрхан сумын Хануй голын төмөр бетон гүүр 109.15 у/м, аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар Чулуут сумын Улаалзайн даваа, Зам зухалдах зам засварын ажил /Архнгай Цэнхэр сум/, Цохиотын давааны зам засварын ажил, Жаргалант сумын Бумбат даваа, Өлийн даваа, Улааны давааны зам засвар, Эрдэнэбулган сумын цагаан давааны пост, 2 модны рашааны дунд ослын аюулгүйн зогсолтын талбай, Цэцэрлэг хотын төв доторх авто замд хэвтээ тэмдэг хийх /цагаан зураас/, Эрдэнэбулган сумын авто машины зогсоол, зам засвар, тохижилтын ажил (Нийтийн худалдааны төвийн зогсоол), Наадмын талбайн тохижилт /янгиртай хясааны болон онгоны аманд авто зогсоол байгуулах, хурдан морины зам засах/, Цэцэрлэг хотын авто замын засвар, арчлалт, тохижилтын (Цэцэрлэг хотын авто замын шинэчлэлийн ажил) ажлууд бүрэн дуусаж улсын комисст хүлээлгэн өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өндөр-Улаан багийн Донгой багаас Чулуут сум хүртэлх 65.8 км хатуу хучилттай авто замын ажил 70 хувьтай, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Ихтамир чиглэлийн гүүр 220у/м, авто замын эхлэл 63 км хатуу хучилттай авто замын ажил 95 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.

Мөн аймагт анх удаагаа Аялал жуулчлалын чиглэлээр Хорго-Тэрхийн цагаан нуурын чиглэлд 13 км хатуу хучилттай авто замын ажил хийгдэж байна. Мөн Зам, тээврийн сайдын багцаас Цэнхэр сумын төвөөс Цэнхэрийн халуун усны рашаан хүртэлх 25 км, Тамирын гүүрнээс Тайхар чулуу хүртэлх 3,2 км, Цэнхэр сумын төвөөс Содномдаржаа уул хүртэлх 55 км хатуу хучилттай авто замын зураг, төсөв хийгдэж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Булган сумын төв доторх 1,5 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажил 90 хувьтай, Хайрхан сумын төв доторх 1,5 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажил 70 хувьтай, Цахир сумын төв доторх 1,5 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажил 50 хувьтай, Өндөр-Улаан багийн Донгой багаас Чулуут сум хүртэлх 65.8 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажил 70 хувьтай хэрэгжиж байна.

Хайрхан сумын Хануйн гол дээр төмөр бетон гүүрийн барилгын угсралтын ажил дуусаж улсын комисст хүлээлгэн өглөө. Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн 63 км авто замын барилга угсралтын ажил дууссан улсын комисс ажиллуулах хүсэлтээ явуулаад байна.

---o0o---